210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	188,000.00	136,910.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,754,600.00	1,716,400.00
210807	Газрын төлбөр	1,103,000.00	218,996.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,540,200.00</b>	<b>33,019,250.00</b>

Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,161,800.00	22,905,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,378,400.00	10,113,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,295,400.00</b>	<b>53,224,350.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>53,295,400.00</b>	<b>53,224,350.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,779,000.00	35,778,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,526,300.00	13,526,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,990,100.00	3,919,150.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>355,875,700.00</b>	<b>209,061,587.00</b>
223001	Бусад хөрөнгө	355,875,700.00	209,061,587.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>100,000,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,028,624,500.00</b>	<b>2,910,212,136.13</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,979,523,500.00</b>	<b>1,963,965,719.81</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,725,416,100.00	1,709,858,396.81
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	254,107,400.00	254,107,323.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>828,187,700.00</b>	<b>810,115,159.32</b>
320001	Орон нутгийн төсвөөс	828,187,700.00	810,115,159.32
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,545,000.00</b>	<b>16,996,840.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,545,000.00	16,996,840.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>202,368,300.00</b>	<b>119,134,417.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,600,000.00	119,134,417.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,000,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	90,768,300.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	75,704,841.34
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	241,398,139.41
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,037.00</b>	<b>1,037.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>148.00</b>	<b>148.00</b>
620001	Удирдах ажилтан	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	88.00	88.00
620003	Үйлчлэх ажилтан	34.00	34.00
620004	Гэрээт ажилтан	14.00	14.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>735.00</b>	<b>735.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>563.00</b>	<b>563.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	563.00	563.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>172.00</b>	<b>172.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	172.00	172.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>148.00</b>	<b>148.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00

650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	57.00	57.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38.00	38.00
650010	Гэрээт ажилтан	12.00	12.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>119,116,109.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>109,116,109.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>72,743,858.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>23,206,820.00</b>
210101	Үндсэн цалин	23,206,820.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,998,552.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,998,552.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,876,183.00</b>
210401	Бичиг хэрэг	337,133.00
210402	Тээвэр, шатахуун	589,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,789,423.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,869,423.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,920,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,955,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,955,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,160,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,060,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,757,680.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,008,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,749,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,372,251.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,256,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,116,251.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,116,251.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,000,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>127,411,054.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>127,411,054.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,601,570.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	450,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,852,133.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	109,507,351.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>8,294,944.25</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,294,944.25
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>119,116,109.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>109,116,109.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>72,743,858.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>23,206,820.00</b>
210101	Үндсэн цалин	23,206,820.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,998,552.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,998,552.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,876,183.00</b>
210401	Бичиг хэрэг	337,133.00
210402	Тээвэр, шатахуун	589,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,789,423.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,869,423.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,920,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,955,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,955,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,160,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,060,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,757,680.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,008,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,749,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,372,251.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,256,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,116,251.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,116,251.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,000,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>127,411,054.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>127,411,054.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,601,570.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,852,133.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	109,507,351.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>8,294,944.25</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,294,944.25

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Наранбулаг сумын Засаг дарга нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, хуулийн хүрээнд хүргэнэ” гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн хөгжлийн бодлого
- Эдийн засгийн хөгжлийн бодлого
- Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого
- Засаглалын бодлого зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Наранбулаг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 18.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,742.1 сая төгрөгийн 0.5 хувь буюу 18.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 15.0 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 304.2 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая.төгрөг/		
Мөнгөн хөрөнгө	191.7	457.5	265.8
Авлага	412.4	302.8	-109.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	451.4	489.5	38.1
Үндсэн хөрөнгө	3,554.5	3,684.8	130.3

<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,610.0</b>	<b>4,934.6</b>	<b>324.6</b>
Нийт өр төлбөр	108.1	13.4	94.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,501.9	4,921.2	419.3
Засгийн газрын хувь оролцоо	4,501.9	4,921.2	419.3
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,610.0</b>	<b>4,934.6</b>	<b>324.6</b>

Эх сурвалж: Наранбулаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 457.5 сая төгрөг болж 265.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 302.8 сая төгрөг болж 109.6 сая төгрөгөөр буурсан нь Сум хөгжүүлэх сан, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн авлага барагдуулсан нь нөлөөлжээ.

#### Аудитын илрүүлэлт:

#### **Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв:**

- Түлш халаалтын зардлын 0.8 сая төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 489.5 сая төгрөг болж 38.1 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

#### Аудитын илрүүлэлт:

#### **Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв:**

- Ковид-19 цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй ирсэн 5.2 сая төгрөгийн материал бүртгэлд тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулав.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,684.8 сая төгрөг болж 130.3 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

#### **Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв:**

- Санхүүгийн тайланд 9.7 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө буюу газрыг биет хөрөнгөөр тайлагнасныг залруулав.

#### **Наранбулаг сумын Соёлын төв:**

- Санхүүгийн тайланд 2.3 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө буюу газрыг биет хөрөнгөөр тайлагнасныг залруулав.

### 3.5.5 Өр төлбөр

#### Аудитын илрүүлэлт:

#### **Наранбулаг сумын Соёлын төв:**

- Түлш халаалтын зардлын 1.0 сая төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд өглөг тусгуулан залруулга хийлгэв.

### **3.5.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,921.2 сая төгрөг болж 419.3 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 382.7 сая төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 45.3 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.5.7 Орлогын данс**

Тайлант онд татварын орлого 152.3 сая, татварын бус орлого 171.5 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,733.3 сая, нийт 4,057.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### **3.5.8 Зардлын данс**

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 0.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

### **Аудитын илрүүлэлт:**

#### **Наранбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

- Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаар заасан ч Цагдаагийн хэсгийн интернэт, торгуулийн машины төлбөрт 0.3 сая төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Наранбулаг сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2/03 дугаар тогтоолоор 1,267.7 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 5/01 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 17.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,284.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,028.6 сая төгрөгийн төсөв баталснаас 1,979.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 828.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 202.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,964.0 сая, орон нутгийн төсвөөс 810.1 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 17.0 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 119.1 сая, нийт 2,910.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,744.5 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 15.6 сая, орон нутгийн төсөвт 859.8 сая, нийт 875.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,744.5 сая төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь зардлыг 284.1 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Наранбулаг сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 05/01 дүгээр тогтоолд зааснаар Наранбулаг сумын Засаг дарга тайлант онд 60.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 125.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 206.1 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 9.9 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 10.8 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 7.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 99.2 сая, нийт 127.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 119.1 сая төгрөгийг зарцуулж Эрүүл мэндийн төв 8.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Наранбулаг сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 152, хугацаа хоцроож 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Засаг даргын тамгын газар: Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Цэцэрлэг: Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэм мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Ерөнхий боловсролын сургууль: 2014 оноос хойш барагдахгүй байгаа хувь хүмүүсээс авах авлага дансны үлдэгдэл 2.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Эрүүл мэндийн төв: Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 15.6 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Соёлын төв: Цалин тогтоолт, тушаал шийдвэрүүд, цалингийн тооцоо, өглөг, авлагын талаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Наранбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 19.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 19.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчлийг залруулав.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	0.3			1	0.3				
2	ЭМТ	3	15.7	3	15.7						
3	Соёлын төв	2	3.3	2	3.3						
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>19.3</b>	<b>5</b>	<b>19.0</b>	<b>1</b>	<b>0.1</b>				

#### 4. Аудитын илрүүлэлт

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Засаг даргын тамгын газрын үнэ төлбөргүй хүлээн авсан 64.7 сая төгрөгийн бараа материалыг нэгтгэсэн санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн байсныг залруулав.
2. Цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн зарлагыг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байсныг залруулав.
3. Төрийн сангийн санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1.3 сая, өр төлбөрийн үлдэгдлийг 2.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байсныг залруулав.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Наранбулаг сумын Засаг дарга	4	68.3	4	68.3						
<b>НИЙТ</b>		<b>4</b>	<b>68.3</b>	<b>4</b>	<b>68.3</b>						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 03 сарын 25-ны өдөр